



Columbia College
Vancouver, Canada

www.columbiacollege.ca

Колумбия Коллеж

Колумбия Коллеж нь 1936 онд байгуулагдсан бөгөөд Канадын хамгийн анхны бие даасан, олон улсын коллежийн нэг юм. Манай коллеж нь 75 гаруй жилийн хугацаанд мянга мянган оюутнуудыг Канадын болон Америкийн Их Сургуулиудад суралцаж амжилттай төгсөхөд нь бэлтгэсээр ирсэн. Канадын Ванкувер хотноо орших Колумбия коллеж нь саяхан нүүж орсон тохилог, орчин үеийн байрандаа дараахь дөрвөн төрлийн хөтөлбөрийг санал болгож байна.

■ Их сургууль руу шилжин суралцах хөтөлбөр Энэхүү хөтөлбөрөөр оюутнуудад их сургуулийн ерөнхий боловсрол олгох ба үгээр Их сургуулийн нэг эсвэл хоёр дахь жилийн хөтөлбөрийг зааж, Бритиш Колумбын Их сургууль болон бусад Канадын их дээд сургуульд шилжин суралцах боломжийг олгодог. Колумбия Коллежийн Их Сургуулийн хөтөлбөрийн ангиуд нь цөөн тооны оюутантай, энэ нь оюутнуудад багш, профессоруудтай улам ойр дотно харилцаж, тэднээс суралцах боломжийг олгодог. Дараахь хөтөлбөрүүдийг санал болгож байна. Үүнд:

- Бизнес
- Компьютер, мэдээллийн технологи
- Инженер
- Олон нийтийн холбоо харилцаа
- Шинжлэх ухаан
- Хүмүүнлэгийн ухаан

■ Манай Коллеж нь мөн Хүмүүнлэгийн Ухаан (Arts) болон Шинжлэх Ухаан (Science) гэсэн хоёр төрлөөр коллежийн 2 жилийн диплом (Associate Degree)-ийн зэрэг олгодог. Үүнд:

- Хүмүүнлэгийн ухааны дипломын зэрэг
- Хүмүүнлэгийн ухааны дипломын зэрэг (Бизнесийн удирдлага)
- Хүмүүнлэгийн ухааны дипломын зэрэг (Эдийн засаг)



- Хүмүүнлэгийн ухааны дипломын зэрэг (Олон нийтийн харилцаа, холбоо)
- Шинжлэх ухааны дипломын зэрэг
- Шинжлэх ухааны дипломын зэрэг (Математик)
- Шинжлэх ухааны дипломын зэрэг (Компьютерийн шинжлэх ухаан)


2 жилийн дипломын зэргийг их сургуулийн түвшний хичээлийг коллежид 2 жил үзэж, кредитийн шаардлагыг хангасан бол олгодог.

- Их Сургуулийн суурь бэлтгэл хөтөлбөр нь 11 болон 12-р ангийн түвшний хичээлүүдийг заана. Энэ хөтөлбөрийг мужийн захиргаа баталдаг ба бусад бүрэн дунд сургуулиудийн хичээлийн системтэй ижил хөтөлбөр юм. Оюутнууд энэхүү хөтөлбөрт суралцсанаар Бритиш Колумбия Мужаас олгодог бүрэн дунд боловсролын дипломтой төгсөх юм.
- Их дээд сургуулийн Англи Хэлний хөтөлбөр нь Англи хэлээ сайжруулах зорилготой оюутнуудыг бэлтгэдэг ба коллежид элсэн орохын тулд тус хөтөлбөрт хамрагдана.



НҮБ-ийн Хүний Хөгжлийн Индексэд зааснаар Канад улс нь дэлхийн хамгийн хөгжилтэй орнуудын нэгд орох ба Ванкувер хот нь Номхон далайн Баруун эргийн дагуу байрлах Канадын 3 дахь том хот юм. Олон улсын санал асуулгаар Ванкувер хот нь амьдрахад хамгийн таатай, цаг агаар сайтай, байгалийн үзэсгэлэнт орчин, өндөр хөгжсөн нийтийн тээвэр, харилцаа холбооны дэд бүтэц, аюулгүй орчин бүхий хотоор шалгарсан бөгөөд олон үндэстний соёл бүхий хоёр сая орчим иргэд тус хотод амьдарч байна.

Их Дээд сургуулийн шат дараалсан боловсролын схем



University of British Columbia (UBC)

Simon Fraser University (SFU)

University of Victoria (UVIC)



438 Terminal Avenue
Vancouver, BC
Canada V6A 0C1
T: +1 604 683 8360
F: +1 604 682 7191
E: admin@columbiacollege.ca
W: www.columbiacollege.ca

Columbia College
Established 1936

Mongolian 2015/16

Колумбия Коллежид элсэхэд бүрдүүлэх бичиг баримт

Манай коллежид суралцах хүсэлтэй оюутнууд хамгийн багадаа 15 2/1 настай, мөн хангалттай түвшинд бүрэн дунд боловсролыг дүүргэсэн байх шаардлагатай. Хэрвээ таны Англи хэлний түвшин заасан хэмжээнд хүрэхгүй байгаа бол манай коллежийн англи хэлний програмд бүртгүүлж суралцах боломжтой. Үүнд: Их сургуулийн Англи хэлний хөтөлбөр эсвэл Кредитгүй Англи хэлний хөтөлбөр зэрэг багтана.

Хичээл эхлэх өдөр

Хөтөлбөр 9, 1, 5-р саруудад эхэлдэг.
Намрын хичээл: 9-12-р сар хүртэл
Өвлийн хичээл: 1- 4-р сар хүртэл
Зуны хичээл: 5- 8-р сар хүртэл

Хөтөлбөрийн төлбөр (Канад Доллар)

Мэдүүлгийн төлбөр \$150
Бичиг баримт дүгнэх төлбөр \$200
Сургалтын төлбөрийн урьдчилгаа \$12000*

*Үүнд хичээлийн хоёр семестр багтана (24 кредит хичээл, нэг кредит нь \$500)

Орон Байр

Канад гэр бүлд байрлах \$800/сард (өдрийн гурван хоолтой)
Хамт амьдрах гэр бүл олж өгсөний төлбөр \$250

Хоёр семестер буюу 8 сарын хугацаанд амьдрах зардал (ойролцоогоор)

Амьдрах өрөө, байр \$6400
Нийтийн тээвэр \$588
Эрүүл Мэндийн Даатгал \$554
Бусад зардал \$2400
Нийт амьдрах зардал \$9942

